

**АВТО ТЭЭВРИЙН “ТАВ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ПРОТОКОЛ**

Улаанбаатар хот

2015.04.25

Хурлын ирцийн тодорхойлол бол дараах байдалтай байна. С.Ганболд 30907ш, С.Сэргэлэн 24044ш, С.Зоригоо 15755ш, Ундармаа 30778ш, С.Мягмарсүрэн- 130ш, Баясгалан-269ш, Э.Амарсайхан- хувьцааны эрхгүй, А.Мөнхдулам- хувьцааны эрхгүй, Г.Золбаяр- хувьцааны эрхгүй, Д.Баттулга-хувьцааны эрхгүй, Э.Цэндсүрэн- хувьцааны эрхгүй.

“Тав” ХК нь 2015 оны 04 сарын 27 өдрийн 12:00 цагт “Тав” ХК-ны хурлын танхимд хувь нийлүүлэгчдийн 2015 оны ээлжит хурлыг зохион байгуулах гэж байна. Тус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

- 2014 үйл ажиллагааны тайланг хэлэлцэх тухай
- Ноогдол ашиг хуваарилах тухай
- ХК-г өөрчлөн ХХК болох тухай
- ТУЗ-н гишүүдийг сонгох тухай
- ТУЗ-н дэргэдэх дэд хороодыг байгуулж гишүүдийг сонгох тухай

Шийдвэрлэсэн нь: Нийт 114737 ширхэг буюу 88.9%-ийн саналын эрхээр тус ээлжит хурлыг хуралдах ирц бүрдсэн гэж үзэв.

Хурлын даргыг сонгох тухай:

С.Сэргэлэн: ТУЗ-ын энэ удаагийн ээлжит хурлыг С.Ганболд, Л.Ариунжаргал, Б.Баясгалан нараар даргалуулах саналтай байна.

С.Зоригоо: Гарсан саналыг дэмжиж байна.

С.Сэргэлэн: Хурлын тэргүүлэгчээр С.Ганболдыг сонгох саналтай байна.

С.Зоригоо: Зөвшөөрч байна.

Б.Баясгалан: Зөвшөөрч байна.

С.Мягмарсүрэн: Зөвшөөрч байна.

С.Ганболд: Тооллогын комиссоор Б.Баатар, Х.Түмэнжаргал, Д.Жаргалсайхан нарыг нэр дэвшүүлэх саналтай байна.

С.Мягмарсүрэн: Зөвшөөрч байна уу.

Б.Баясгалан: Зөвшөөрч байна.

С.Сэргэлэн: Дэмжиж байна. Тооллогын комиссын даргаар Х.Түмэнжаргалыг сонгох саналтай байна.

С.Ганболд: Зөвшөөрч байна.

С.Зоригоо: Зөвшөөрч байна.

С.Мягмарсүрэн: Зөвшөөрч байна.

С.Ганболд: Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссоор Д.Жаргалсайхан, Б.Баатар, Х.Түмэнжаргал нарыг томилож тооллогын комиссын даргаар Х.Түмэнжаргалыг сонголоо.

С.Ганболд: Хяналтын зөвлөлийн гишүүдэд дараах хүмүүсийг нэр дэвшүүлэх саналтай байна. Ц.Баярцэнгэл, Э.Өнөрсайхан, Д.Янжинлхам нарыг сонгох саналтай байна.

С.Сэргэлэн: Хяналтын зөвлөл гэдэг бол маш нарийн хариуцлагатай ажил. Дээрх нэр дэвшүүлсэн 3 хүнийг зөвшөөрч байна. Ахлахаар Э.Өнөрсайханыг сонгох саналтай байна.

С.Мягмарсүрэн: Зөвшөөрч байна.

С.Зоригоо: Зөвшөөрч байна.

Б.Баясгалан: Зөвшөөрч байна.

Шийдвэрлэсэн: Хувьцаа эзэмшигчдийн 100%-н саналаар хяналтын зөвлөлийн гишүүдээр Ц.Баярцэнгэл, Э.Өнөрсайхан, Д.Янжинлхам нарыг сонголоо. Хяналтын зөвлөлийн ахлахаар Э.Өнөрсайханыг сонголоо.

С.Ганболд: С.Ундармаа нь төрийн албанд ажилладаг тул өнөөдөр ирж амжсангүй. Утсаар нэдэгдэж саналаа өгсөн байгаа.

Хэлэлцэх асуудлуудыг батлах тухай:

С.Ганболд: Бид энэхүү хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж та бүхэнд хүргүүлсэн байгаа билээ. Хэлэлцэх асуудлууд:

1. 2014 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх тухай.
2. Ноогдол ашиг хуваарилах тухай.
3. ХК-г өөрчлөн ХХК болох тухай
4. ТУЗ-н гишүүдийг нөхөн сонгох тухай.
5. ТУЗ-н дэргэдэх дэд хороодыг байгуулж гишүүдийг сонгох тухай.

С.Ганболд: Хэлэлцэх асуудал дээр нэмж хэлэлцэх асуудал байна уу.

С.Сэргэлэн: Байхгүй. Дээрх хэлэлцэх асуудлуудыг батлах саналтай байна.

С.Мягмарсүрэн: Санал нэг байна.

С.Зоригоо: Нэмэх зүйлгүй. Батлах саналтай байна.

Б.Баясгалан: Зөвшөөрч байна.

Шийдвэрлэсэн нь: Хэлэлцэх асуудал дээр нэмж оруулах санал байгаагүй тул хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Хэлэлцэх асуудал №1: 2014 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх тухай.

С.Ганболд: “Тав” ХК-ийн ерөнхий захирал С.Ганболд 2014 оны үйл ажиллагааны тайланг танилцуулна.

Тайланг хавсаргав.

С.Ганболд: Ерөнхий санхүүч Л.Ариунжаргал 2014 оны санхүүгийн тайланг танилцуулна.

Л.Ариунжаргал: 2014 онд “Тав” ХК нь нийт 1,4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. Нийт 19.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. 2014 онд банкны богино хугацаатай зээлийг барагдууллаа. Иймд бид 2014 онд санхүүгийн хувьд ашигтай ажиллалаа.

С.Ганболд: Санхүүгийн тайлан, аудитын тайлангаас асууж тодруулах зүйл байна уу.

С.Сэргэлэн: Асуух зүйл байхгүй. Санхүүгийн тайлан сайн байна. Ариунжаргал сайн ажилласан байна. Уул уурхай ажил зогсож эдийн засаг муу байгаа учир цаашид зардлаа хэмнэх нь зүйтэй байх гэж бодож байна.

С.Зоригоо: Асуух зүйл байхгүй. 2014 онд сайн ажилласан байна.

С.Мягмарсүрэн: Асуух зүйл байхгүй.

Хэлэлцэх асуудал №2: Ноогдол ашиг хуваарилах тухай:

С.Ганболд: Та бүхэн мэдэж байгаа байх 2014 онд уул уурхай зогсонги байдалтай байж орлого муу байлаа. Ногдол ашиг зарлахаар хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэж цөөхөн ч гэсэн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоё гэж бодож байна. 2014 онд цэвэр ашгаас ногдол ашгийг олгоё. Нэгж хувьцаанд 16 төгрөгийн ногдол ашиг хуваарилагдаж нийт 114737 хувьцаанд 1.835.792 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд олгох нь зүйтэй гэж үзэж байна.

С.Сэргэлэн: Бага ч гэсэн ноогдол ашиг зарласан дээр. Санал нэг байна.

С.Зоригоо: Санал нэг байна.

Б.Баясгалан: Санал нэг байна.

С.Мягмарсүрэн: Санал нэг байна.

Хэлэлцэх асуудал №3: ХК-г өөрчлөн ХХК болох тухай.

С.Ганболд: ХК-г өөрчлөн ХХК болгох энэхүү санал дээр хэлэлцэе. Санал хураалтыг ил байдлаар явуулах уу, далд явуулах уу.

С.Сэргэлэн: Ил байдал нь зүгээр байх. Тооллогын комиссын дарга хяналт тавьчих.

С.Ганболд: Зөвшөөрч байна.

С.Зоригоо: Зөвшөөрч байна.

С.Ганболд: Энэ хуралдаанаар нэг санал хэлэлцэж батлах гэсэн юм. Манай компанийн хувьцааны үнэ маш өндөр байна. Энэ нь сонирхол бүхий хэдэн хүний хийж байгаа ажил гэж би бодож байгаа. Тээвэр их орлого ихтэй үед манай компанийн хувьцааг гадаадын

хэдэн хүн бага бага хэмжээгээр авч байсан юм. Монголын нэг компани гадаадын хэдэн хүнтэй нийлж хувьцаа худалдаж авсан юм. Тэр хүмүүс одоо хувьцааны үнэ өсгөөд байна. Манай компанийн хувьцааг өндөр үнээр авна гэсэн зар тавьсан байсан. Хувьцаа зарах гэсэн юм гээд утасдахаар 1-2 ширхэг хувьцаа аваад илүү авахгүй байгаа юм. тиймээс энэ бол нэг ёсны мөнгөө нөхөж олох гэсэн бодлого явагдаад байгаа учир энэ асуудлыг шалгаж өгөхыг хүсэж байна.

Энэ асуудлыг өнгөрсөн жил хэлэлцсэн билээ. ХК нь ямар нэгэн ажил хөөцөлдөх, бичиг баримт бүрдүүлэх зэрэгт цаг хугацаа ихээр шаардагдаж, хоног алддаг. Бичиг баримт бүрдүүлж 9 хүний гарын үсэг зуруулах гэж цаг их ордог. Тиймээс цаг хугацаа хэмнэх, олон ажил болохгүйн тулд ХХК болсон дээр. ХХК болох баримт бичгийг бүрдүүлж байгаа.

С.Сэргэлэн: Манай компанийн хувьцаа өндөр байна гэж олон хүмүүс зарлаж байсан. Тиймээс энэ асуудлыг шалгуулах нь зөв. Зөвшөөрч байна.

С.Зоригоо: Зөвшөөрч байна.

Х.Түмэнжаргал: Хувьцаа эзэмшигчдийн 4 хүнээс 4 хүн зөвшөөрч 100%-ийн саналтай байна.

С.Ганболд: Өнгөрсөн жилийн ажлын хэсгийг хэвээр үлдээж баримт материал бүрдүүлэх ажлыг даалгаж байна. Ажлын хэсгээр С.Сэргэлэн, Л.Ариунжаргал, Г.Баярмаа нарыг дахин сонгож ажлын хэсгийн ахлагчаар С.Сэргэлэнг томилох саналтай байна.

С.Сэргэлэн: Зөвшөөрч байна. Ажлын хэсэг байгуулах нь маш зүйтэй.

С.Зоригоо: Зөвшөөрч байна.

С.Мягмарсүрэн: Зөвшөөрч байна.

Б.Баясгалан: Зөвшөөрч байна.

С.Ганболд: Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргаж хувьцааны өсөлтийг шалгуулах нь зөв гэж үзлээ. 100%-ийн саналаар ХК-г өөрчлөн ХХК-өөр зөвшөөрч байна гэж үзлээ.

Ажлын хэсгээр С.Сэргэлэн, Л.Ариунжаргал, Г.Баярмаа нарыг томилож, ажлын хэсгийн ахлагчаар С.Сэргэлэнг томилов.

Шийдвэрлэсэн нь: 100%-н саналаар “Тав” ХК-н хувьцааны үнийн өсөлтийг санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргаж шалгуулахыг зөвшөөрлөө. Хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар ХК-г өөрчлөн ХХК болохыг зөвшөөрлөө.

Ажлын хэсгээр С.Сэргэлэн, Л.Ариунжаргал, Г.Баярмаа нарыг томилож, ажлын хэсгийн ахлагчаар С.Сэргэлэнг томилов.

Хэлэлцэх асуудал №4: ТУЗ-н гишүүдийг нөхөн сонгох тухай.

С.Ганболд: ТУЗ-н гишүүдийг нөхөн сонгох тал дээр хэлэлцэе.

С.Ганболд: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг жил болгон хурлаар батлаж байх ёстой байдаг. Бид энэ хурлаар гишүүдээ нөхөн батлана. 2 жилийн хугацаатайгаар нэг удаа гишүүдээ батлаж байхаар өнгөрсөн жилийн хуралд батласан байгаа. Д.Эрдэнэхишиг- бие нь муудаж ажлаас чөлөөлөгдсөн, Я.Дашдуламжав- Өндөр настны тэтгэвэрт гарсан тул дээрх гишүүдийг А.Мөнхдулам, Э.Цэндсүрэн нараар нөхөн сонгох саналтай байна.

С.Зориггоо: Нөхөн сонгогдож байгаа гишүүдийг зөвшөөрч байна.

С.Сэргэлэн: Зөвшөөрч байна.

С.Мягмарсүрэн: Зөвшөөрч байна.

Б.Баясгалан: Зөвшөөрч байна.

Шийдвэрлэсэн нь:

Хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн С.Ганболд, С.Сэргэлэн, С.Зориггоо, С.Ундармаа, Г.Золбаяр, Д.Баттулга, Э.Амарсайхан, А.Мөнхдулам, Э.Цэндсүрэн нарыг сонгож батлав. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хоёр жилийн хугацаатайгаар батлав.

Хэлэлцэх асуудал №5: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэд хороодыг батлах тухай.

С.Ганболд: Дэд хороодыг байгуулахын тулд ТУЗ-ын 9-н гишүүдийг 3-н дэд хороодын гишүүдээр томилж, дэд хорооны даргыг хараат бус хүнээр сонгох хуулийн заалттайг бүгд мэдэх байх.

С.Сэргэлэн: Өнгөрсөн жил томилогдсон гишүүдээ хэвээр үлдээж нөхөн сонгогдож байгаа хоёр гишүүнийг хасагдсан хоёр гишүүний оронд томилвол зүгээр гэж үзэж байна. Хараат бус даргаар нь Б.Баясгалан сонгох саналтай байна.

С.Зоригоо: Зөвшөөрч байна.

С.Мягмарсүрэн: Санал нэг байна. Зөвшөөрч байна.

Б.Баясгалан: Зөвшөөрч байна.

Аудитийн хороонд С.Зоригоо, Д.Баттулга, Э.Цэндсүрэн

Цалин урамшууллын хороонд: С.Ганболд, Г.Золбаяр, А.Мөнхдулам


Нэр дэвшүүлэх хороонд: С.Сэргэлэн, С.Ундармаа, Э.Амарсайхан нарыг дэвшүүллээ.

Шийдвэрлэсэн нь: Аудитийн хороонд: С.Зоригоо, Д.Баттулга, Э.Цэндсүрэн

Цалин урамшууллын хороонд: С.Ганболд, Г.Золбаяр, А.Мөнхдулам

Нэр дэвшүүлэх хороонд: С.Сэргэлэн, С.Ундармаа, Э.Амарсайхан томилов.


Дэд хороодын даргаар Б.Баясгаланг томилов.

Протокол хөтөлсөн: ТУЗ-н нарийн бичгийн дарга  Г.Баярмаа


Протоколтой танилцсан:


ТУЗ-ийн дарга:  /С.Ганболд/


Гишүүд  /С.Сэргэлэн/


 /С.Зоригоо/


 /С.Ундармаа/

 /Г.Золбаяр/

 /Д.Баттулга/

 /А.Мөнхдулам/

 /Э.Цэндсүрэн/

 Э.Амарсайхан